**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дорнод аймгийн Төв номын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/36/СТА-ТШЗ***

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Гэрээт аудитор: З.Шинэхүү
Утас: 7058-4204, Цахим хаяг: Shinekhuuz@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. Аудитын тайлан ..... 10
3.1. Ерөнхий зүйл ..... 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 10
3.4. Материаллаг байдал ..... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 11
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12
3.9. Аудитын илрүүлэлт ..... 13
Залруулсан алдаа ..... 13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 13
Аудитын зөвлөмж ..... 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 13
4. Менежментийн захидал ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 14

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 228

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ Ж.ЦАГААН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн төв номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн төв номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн төв номын сангийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021297

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх  үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,242,102.00** | **36,984,112.00** |
| **33** | **АВЛАГА** | - | 780,810.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 780,810.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33,242,102.00 | 36,203,302.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 33,242,102.00 | 36,203,302.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 425,600.00 | 408,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,269,892.00 | 28,247,892.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 198,500.00 | 198,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,488,500.00 | 3,488,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,859,610.00 | 3,859,610.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **950,302,653.96** | **959,179,934.61** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 950,302,653.96 | 959,179,934.61 |
| **392** | **Биет хөрөнгө** | 906,141,653.82 | 915,219,134.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 779,199,676.00 | 801,985,966.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (22,310,863.08) | (44,977,761.90) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,400,000.00 | 21,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,400,000.00) | (21,400,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,036,209.60 | 40,521,209.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (22,395,381.23) | (25,871,242.15) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,895,418.00 | 60,679,418.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,057,129.96) | (38,252,069.61) |
| 39217 | Ном | 115,773,724.49 | 121,133,614.49 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 44,161,000.14 | 43,960,800.18 |
| 39301 | Програм хангамж | 3,683,900.00 | 3,683,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,822,899.86) | (3,023,099.82) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,300,000.00 | 43,300,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **983,544,755.96** | **996,164,046.61** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **780,810.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 780,810.00 |
| **413** | **Өглөг** | - | 780,810.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 780,810.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 780,810.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **983,544,755.96** | **995,383,236.61** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 983,544,755.96 | 995,383,236.61 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 272,721,782.49 | 272,721,782.49 |
| 51101 | Өмч: - төрийн | 272,721,782.49 | 272,721,782.49 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 366,705,952.14 | 378,544,432.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 366,705,952.14 | 366,705,952.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 11,838,480.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 344,117,021.33 | 344,117,021.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **983,544,755.96** | **996,164,046.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **201,808,085.60** | **279,246,280.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,422,985.60** | **37,101,880.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,422,985.60 | 37,101,880.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,422,985.60 | 37,101,880.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 20,422,985.60 | 37,101,880.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **181,385,100.00** | **242,144,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,536,000.00 | 3,330,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 400,000.00 | 330,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 175,849,100.00 | 238,814,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 175,849,100.00 | 238,814,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **211,331,544.86** | **267,407,799.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **211,331,544.86** | **267,407,799.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 211,118,503.86 | 250,007,276.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 138,584,650.00 | 168,503,137.77 |
| 210101 | Үндсэн цалин | 138,584,650.00 | 168,503,137.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,375,423.00 | 21,447,707.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,375,423.00 | 21,447,707.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,738,094.00 | 12,063,688.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,335,740.00 | 2,311,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,775,583.00 | 7,373,776.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,626,771.00 | 2,378,912.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,048,896.00 | 7,859,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 433,960.00 | 992,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,516,848.00 | 1,147,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 754,400.00 | 2,869,630.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 528,000.00 | 578,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,515,688.00 | 1,772,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 511,800.00 | 5,300,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 97,800.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 414,000.00 | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 282,400.00 | 476,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 282,400.00 | 476,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 909,600.00 | 1,489,404.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 246,400.00 | 1,146,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 124,700.00 | 124,704.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,667,640.86 | 32,867,899.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,136,000.00 | 1,330,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,531,640.86 | 31,537,899.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 213,041.00 | 17,400,523.06 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 180,000.00 | 17,391,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 17,391,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 33,041.00 | 9,523.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,041.00 | 9,523.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(9,523,459.26)** | **11,838,480.65** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(9,523,459.26)** | **11,838,480.65** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **181,385,100.00** | **242,144,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **181,385,100.00** | **242,144,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,536,000.00 | 3,330,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 400,000.00 | 330,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 175,849,100.00 | 238,814,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 175,849,100.00 | 238,814,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **181,385,100.00** | **242,144,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **181,385,100.00** | **242,144,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **181,172,059.00** | **224,545,876.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 138,584,650.00 | 168,503,137.77 |
| 210101 | Үндсэн цалин | 138,584,650.00 | 168,503,137.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,375,423.00 | 21,447,707.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,834,488.00 | 14,584,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,385,232.00 | 1,716,407.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,108,188.00 | 1,372,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 277,046.00 | 343,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,770,469.00 | 3,431,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,738,094.00 | 12,063,688.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,335,740.00 | 2,311,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,775,583.00 | 7,373,776.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,626,771.00 | 2,378,912.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,634,092.00 | 10,094,140.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 433,960.00 | 1,138,430.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,516,848.00 | 1,147,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,151,864.00 | 6,045,050.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 528,000.00 | 578,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 703,420.00 | 685,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 511,800.00 | 9,339,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 97,800.00 | 4,339,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 414,000.00 | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 282,400.00 | 476,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 282,400.00 | 476,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 909,600.00 | 1,489,404.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 246,400.00 | 1,146,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 124,700.00 | 124,704.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,136,000.00 | 1,132,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,136,000.00 | 1,132,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **213,041.00** | **17,598,523.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 180,000.00 | 17,589,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 17,391,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 180,000.00 | 198,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 33,041.00 | 9,523.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 33,041.00 | 9,523.06 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 272,721,782.49 | 344,117,021.33 | 372,268,691.40 | | 989,107,495.22 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 3,960,720.00 | | 3,960,720.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,721,782.49** | **344,117,021.33** | **376,229,411.40** | - | 993,068,215.22 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (9,523,459.26) | | (9,523,459.26) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,721,782.49** | **344,117,021.33** | **366,705,952.14** | - | 983,544,755.96 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **272,721,782.49** | **344,117,021.33** | **366,705,952.14** | - | 983,544,755.96 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,721,782.49** | **344,117,021.33** | **366,705,952.14** | - | 983,544,755.96 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 11,838,480.65 | | 11,838,480.65 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,721,782.49** | **344,117,021.33** | **378,544,432.79** | - | 995,383,236.61 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 238814400.00 | 235474876.94 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 238814400.00 | 235474876.94 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 221423400.00 | 218281876.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 168504400.00 | 168503137.77 |
| 210101 | Үндсэн цалин | 168504400.00 | 168503137.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21448100.00 | 21447707.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14584200.00 | 14584200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1716800.00 | 1716407.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1372500.00 | 1372500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 343100.00 | 343100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3431500.00 | 3431500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12066500.00 | 12063688.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2311000.00 | 2311000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7374000.00 | 7373776.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2381500.00 | 2378912.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8094900.00 | 6094140.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1138600.00 | 1138430.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500000.00 | 500000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,147,500.00 | 1,147,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,045,300.00 | 2,045,050.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 578,000.00 | 578,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 685,500.00 | 685,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,340,000.00 | 9,339,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,340,000.00 | 4,339,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 476,000.00 | 476,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 476,000.00 | 476,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,493,500.00 | 1,489,404.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 38,500.00 | 38,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,150,000.00 | 1,146,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 125,000.00 | 124,704.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,391,000.00 | 17,193,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,391,000.00 | 17,193,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,391,000.00 | 17,391,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 238,814,400.00 | 238,814,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 238,814,400.00 | 238,814,400.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,536,000.00** | **3,330,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,536,000.00** | **3,330,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,356,000.00 | 3,132,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 2,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 2,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 160,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,136,000.00 | 1,132,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,136,000.00 | 1,132,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 180,000.00 | 198,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 180,000.00 | 198,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 180,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 198,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 3,330,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3,330,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 330,000.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Төв номын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Ж.Цагаан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 24–ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор З.Шинэхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Төв номын сан 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод аймгийн Төв номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Мэдээллийг нээлттэй хүргэх түшиц газар байна.”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорнод аймгийн Төв номын сан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт, дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 267,407.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 5,348.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймгийн Төв номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,619.3 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 780.8 | 780.8 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 33,242.1 | 36,203.3 | 2,961.2 |
| Үндсэн хөрөнгө | 950,302.6 | 959,179.9 | 8,877.3 |
| **Нийт хөрөнгө** | **983,544.7** | **996,164.0** | **12,619.3** |
| Өр төлбөр | - | 780.8 | 780.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 983,544.7 | 995,383.2 | 11,838.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **983,544.7** | **996,164.0** | **12,619.3** |

Авлага, өглөгийн дансны үлдэгдэл 780.8 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсан тул санхүүгийн тайлангаар авлага, өглөг үүсгүүлсэн**.**

Бараа материалын дансны үлдэгдэл 36,203.3 мянган төгрөг болж 2,961.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 959,179.9 мянган төгрөг болж 8,877.3 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө нөлөөлсөн байна.

Дорнод аймгийн Төв номын сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 77,438.1 мянган төгрөгөөр буюу 38.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 56,076.3 мянган төгрөгөөр буюу 26.5 хувиар өссөн байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 279,939.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 279,939.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 41,124.7 мянган төгрөгөөр бууруулж 238,814.4 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 238,814.4 мянган төгрөгийн төсөв батласныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 238,814.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал үйл ажиллагаанд 238,804.9 мянган төгрөгийг зарцуулж 9.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 238,804.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого

Улсын /орон нутгийн/ төсөвт орлого төвлөрүүлдэггүй байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд 3,330.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж бараа үйлчилгээний зардалд бүрэн зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа бүрэн мэдээлсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,561.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 780.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 780.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос 780.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцон нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулав.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 780.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүллээ.

Үүнд:

Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтнаас 780,810.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..."гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: **2020** 3

Аудитын нэр: ***Дорнод аймгийн Төв номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/36/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: ***Дорнод аймгийн Төв номын сан***

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос 780,810.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулсан. | 780.8 | Албан шаардлага | Захирал, Нягтлан бодогч | Ж.Цагаан Б.Майцэцэг |
| **ДҮН** | | 780.8 | | | |